



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2014 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 23

Шарга

Г Чуулга уулзалт зохион байгуулах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, 20.1.10 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 02 дугаар сарын 10-ний 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1. Монголын Залуучуудын Холбооны дэргэдэх Хөвсгөл аймгийн Залуучуудын Холбооны санаачлагыг дэмжин “Эв нэгдэл - Залуучуудын оролцоо” чуулга уулзалтыг жилийн ажлын төлөвлөгөөтэй уялдуулан хамтран зохион байгуулсугай.

2. Чуулга уулзалтын хөтөлбөрийг 1 дүгээр, зохион байгуулах ажлын хэсгийг 2 дугаар, үйл ажиллагааг зохион байгуулахад зарцуулах төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Батлагдсан зардлыг төсвийн холбогдох зардлуудаас гаргаж зарцуулахыг төсвийн ерөнхий менежер /Ч.Мөнхцэцэг/, ня-бо /Ж.Пүрэвжав/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Ч.Мөнхцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.АЗБАЯР

00000

**“ЭВ НЭГДЭЛ-ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦОО”
ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ХӨТӨЛБӨР**

1. 2014 оны 06 дугаар сарын 27-нд:

- 10:00-12:00 - Чуулга уулзалтанд оролцогчдыг бүртгэх, мандат олгох
- 13:00-19:00 - “Гар бөмбөг”-ийн тэмцээний үйл ажиллагаа эхэлнэ
- 20:00-22:00 - Нээлтийн үйл ажиллагаанд зориулсан урлагийн тоглолт
- 22:00-24:00 - “Архи тамхинаас татгалзая” уриан дор АХА тэмцээн, цэнгүүн

2. 2014 оны 06 дугаар сарын 28-нд:

- 07:00-09:30 - “Хөдөлгөөн эрүүл мэнд” уриан дор явган аялал, чөлөөт үйл ажиллагаа
- 09:30-10:00 – “Эв нэгдэл-Залуучуудын оролцоо” чуулга уулзалтын нээлт
- 10:00-10:30 - “Сумын хөгжил өнөөгийн байдал” илтгэл
- 10:30-11:00 - Хэлэлцүүлэг
- 11:00-11:30 – “Залуучуудын оролцоо орон нутагт” илтгэл
- 11:30-12:00 - Хэлэлцүүлэг
- 12:00-13:00 – “Хүний хөгжил” илтгэл
- 13:00-13:30 – Хэлэлцүүлэг
- 13:30-14:30 - Үдийн цай
- 14:30-15:00 - “Монгол залуу хүн” илтгэл
- 15:00-15:30 - Хэлэлцүүлэг
- 15:30-16:00 - “Залуу гэр бүл ба төлөвлөлт” илтгэл
- 16:00-16:30 - Хэлэлцүүлэг
- 16:30-17:00 - “Нутагтаа сайхан амьдарцгаая” илтгэл
- 17:30-18:00 - Хэлэлцүүлэг
- 18:00-18:30 – Уриалгын төсөл хэлэлцэж батлах
- 18:30-19:00 - Дурсгалын зураг татуулах
- 21:00-24:00 – “Иргэн бүр Иргэний хуулиа судалъя” уриан дор АХА тэмцээн, цэнгүүн

3. 2014 оны 06 дугаар сарын 29-нд:

- 10:00 цагт- Тэмцээний үргэлжлэл /Тэмцээнд амжилттай оролцсон баг, тамирчдаас аймгийн хэмжээний уриалга гаргах хаалтын нэгдсэн үйл ажиллагаанд оролцуулахаар сонгон шалгаруулна./
- 20:00-24:00 – Галын наадам, хаалтын үйл ажиллагаа

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2014 оны 06 сарын 04-ний
23 дугаар тогтоолын 8 дугаар Хавсралт

**“ЭВ НЭГДЭЛ - ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦОО” ЧУУЛГА УУЛЗАЛТЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Азбаяр /Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга/

Нарийн бичиг: Ч.Мөнхцэцэг /Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн даргын үүрэг
гүйцэтгэгч/

Гишүүд: Э.Эрдэнэцэцэг /Засаг даргын орлогч/

Ч.Нацагдорж /Хөвсгөл аймгийн Залуучуудын Холбооны тэргүүн/

Д.Батцоож /Хөвсгөл аймгийн Залуучуудын Холбооны нарийн бичгийн дарга/

С.Эрдэмтөгс /Засаг даргын Тамгын газрын нярав/

Ж.Жамбалсүрэн /1-р багийн Засаг дарга/

Ж.Бумцэнд /2-р багийн Засаг дарга/

О.Шадав /3-р багийн Засаг дарга/

Б.Баасанчулуун /4-р багийн Засаг дарга/

Г.Бадрал /5-р багийн Засаг дарга/

Н.Алтанбаатар /6-р багийн Засаг дарга/

Ч.Өнөржаргал /Сумын Залуучуудын Холбооны төлөөлөл/

Л.Баттулга /Засаг даргын Тамгын газрын БТС-ын арга зүйч/

Н.Дашдаваа /Соёлын төвийн эрхлэгч/

Ж.Цэрэнхүү /Чийрэгжүүлэлтийн сувилагч/

“Сумын залуус” төсөлд хамрагдаж буй оюутнууд

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2014 оны 06 сарын 04-ний
23 дугаар тогтоолын 3 дугаар Хавсралт

**"ЭВ НЭГДЭЛ-ЗАЛУУЧУУДЫН ОРЛЦОО"
ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ТӨСӨВ**

№	Зардлын нэр	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Тэмдэглэлийн дэвтэр	300	800	240,000
2.	Бал	300	200	60,000
3.	Өдрийн унд	300	1000	300,000
4.	АХА тэмцээн	2	20,000	40,000
5.	Гар бөмбөг /3 байр/	2	100,000	200,000
6.	Хулдаасан хэвлэл	1	50000	50000
7.	Мандат	300	100	30000
8.	Тээвэр шатахуун			80000
	Нийт			1,000,000

oOo